



**2023 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГАА
БОЛОН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Улаанбаатар хот, 2024 он



Borderless **Fintech.**

Агуулга

01. Бизнесийн үйл ажиллагаа

Компанийн тухай	5
Онцлох үйл явдал	6
Зээлийн үйл ажиллагаа	11
Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа	15
Нийгэмд үзүүлсэн үр нөлөө, нийгмийн хариуцлага	16
Харилцагчийн үйлчилгээ	

02. Санхүүгийн тайлагнал

Аудитын дүгнэлт	18
Санхүү байдлын тайлан	20
Орлого үр дүнгийн тайлан	20
Мөнгөн гүйлгээний тайлан	21
Өмчийн өөрчлөлтийн тайлан	21

03. Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага	23
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	24

04. Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн хурал	27
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, үйл ажиллагаа	28
Хувьцааны ханш	29
Ногдол ашгийн бодлогын хэрэгжилт	



01.

Бизнесийн үйл ажиллагаа

Компанийн тухай

Алсын хараа:


Харилцагчид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн хурдан, хамгийн бага зардлаар хүргэх дэлхийн стандартад нийцсэн санхүүгийн эко дэд бүтцийг бий болгох.

Эрхэм зорилго:

Ажилтан бүрийн чин сэтгэлээр санхүүгийн хүртээмжтэй үйлчилгээг хэрэглэгч бүрт найдвартай хүргэнэ.

Үнэт зүйлс:

Мэргэжлийн өндөр ур чадвартай баг хамт олон, харилцагч, технологи, мэдээллийн аюулгүй байдал, харилцагчийн үйлчилгээ.



Нийт ажилтан

112

Эмэгтэй **77**

Эрэгтэй **35**

85%

Банк санхүүгийн салбарт гурваас дээш жил ажилласан туршлагатай ажилтан

8

ажилтан гадаад улсад бакалаврын болон магистрын зэрэг хамгаалсан

4

ажилтан мэргэшсэн нягтлан бодогч

21

ажилтан Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрхтэй.

Онцлох үйл явдал



Анх удаа 8.5 тэрбум төгрөгийн нээлттэй бонд татан төвлөрүүлсэн.

2023 оны анхны нээлттэй бондыг Монголын хөрөнгийн бирж дээр амжилттай гаргаж, нийт 8.5 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулагчдаас 1 цагийн дотор татан төвлөрүүлж чадсан.



Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2013 стандартыг нэвтрүүлээ.


Бид хэрэглэгч, харилцагчдынхаа мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах, системийн хэвийн, найдвартай ажиллагааг бүрэн хангах чиглэлээр ажиллаж ирсэн бөгөөд 2022 оны есдүгээр сараас эхлэн үе шаттай төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсний үр дүнд ийнхүү мэдээллийн аюулгүй байдлын стандартын гэрчилгээгээ 2023 оны дөрөвдүгээр сард гардан авсан.



SENDLY, HIPAY аппликэйшнээр дамжуулан БНХАУ-ын ALIPAY данс руу мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсон.

БНХАУ-ын "Ant Group"-ийн охин компанитай энэ оны 3 дугаар сарын нэгний өдрөөс албан ёсоор хамтын ажиллагаагаа эхлүүлснээр Олон Улсын мөнгөн гуйвуулгын Sendly, мөн Hipay аппликэйшнээр дамжуулан Монголчууд БНХАУ-ын иргэдийн Alipay данс руу түргэн шуурхай, найдвартайгаар мөнгөн гуйвуулгаа илгээх боломжтой боллоо. Alipay нь БНХАУ-ын иргэдэд аюулгүй, найдвартай төлбөрийн олон сонголтыг санал болгохоос гадна, Alipay мини программууд, амьдралын хэв маягийг хялбарчилсан үйлчилгээнүүд, мөн бусад хэрэгслүүдээрээ дамжуулан Хятад улс дотроо харилцах, төрөл бүрийн дижитал үйлчилгээ авах боломжийг олгодог юм.

Онцлох үйл явдал



"Сэндли" ББСБ ХК 614 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилсан.

"Сэндли ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн ээлжит хурлаар компанийн 2022 оны цэвэр ашгийн 20.064 хувь буюу 614,817,500 төгрөгийг хувьцаа эзэмшигч нартаа хуваарилахаар шийдвэрлэлээ. Энэ хүрээнд нэгж хувьцаанд ногдох ашиг 2.75 төгрөг байхаар тогтсон. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөр тасалбар болгон тогтоож, ногдол ашгийг 2023 оны 07 дугаар сард "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан.



"UB Marathon 2023" арга хэмжээг Сэндли ББСБ ХК нь "Хай пэймент солюшнс" ХХК-тай хамтран зохион байгуулж, ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсон.

"Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтийг "Хай пэймент солюшнс" ХХК-тай өнгөрсөн оноос хойш хамтран бүртгэлийг 100 хувь цахим болгож, оролцогч тамирчдын хурд, амжилтыг хэмждэг технологийг нэвтрүүлсэн.



2023 оны 7 дугаар сард компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн топ 5 компанийн нэг болсон.


Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс гаргасан 2023 оны 8 сарын 31-ний байдлаар үнэт цаасны төвлөрлийн судалгаагаар хамгийн их хувьцаа эзэмшигч нэмэгдсэн 5 компанийн нэгээр "Сэндли ББСБ" ХК орсон ба шинээр 1663 хувьцаа эзэмшигч нэмэгдсэн байна.

Онцлох үйл явдал

Ховд, Хөвсгөл аймаг, Багануур дүүрэгт салбараа нээснээр 57 салбар, нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Америкийн нэгдсэн улсаас Монгол улсын чиглэлд New York болон Michigan мужууд гүйлгээ хийх боломжтой болсон.



"СЭНДЛИ ББСБ" ХК нь "Paysend" PLC-тэй хамтран ажиллах гэрээ байгуулснаар Монгол улсаас 170 гаруй гадаад улс орон руу ердөө 10 минутын дотор мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсон.




Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбооны "Оны шилдэг санхүүгийн хүртээмжтэй ББСБ" Алтан од 2023 шагналын эзэн болсон.

Зээлийн үйл ажиллагаа

Зээлийн хураангуй тоон үзүүлэлт:




Зээлийн үлдэгдэл: (статус, хүйсээр)




Зээлийн үйл ажиллагаа

Зээлийн үлдэгдлийн эзлэх хувь: (насны ангиллаар)



Зээлийн үлдэгдэл: (төрлөөр)



Зээлийн багцгийн мэдээ



Олгосон зээлийн мэдээ



Зээлийн багцгийн чанар

Өнгөрсөн оны мөн үед нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 5.6 хувь байсан бол 2023 онд 5.4 хувьд хүрч зээлийн эрсдэлийн сангийн нөөц 1.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.




Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа







“Сэндли ББСБ” ХК нь олон улсын мөнгөн гуйвуулгыг Sendly аппликейшнээр дамжуулан хамгийн бага шимтгэлтэйгээр АНУ-аас Монгол, Европын холбооны 27 улсаас Монгол, Монгол улсаас БНХАУ, Монгол картын дугаар ашиглан 79 орон руу илүү хурдан, найдвартай албан ёсны эрхтэйгээр шилжүүлэг хийх боломжийг бүрдүүлэн ажилллаж байна. 2023 оны 9 дүгээр сард "Paysend" PLC-тэй хамтран ажиллах гэрээ байгуулснаар Монгол улсаас 170 гаруй гадаад улс орон луу ердөө 10 минутын дотор мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсон. "Paysend" PLC

бол банкны картаар (Visa эсвэл MasterCard) олон улсын мөнгөн гуйвуулга илгээх, хүлээн авах боломжийг олгодог хэрэглэгчдэд ээлтэй интерфэйс, аюулгүй байдлын дэвшилтэт технологи бүхий санхүүгийн платформ юм. Ингэснээр Sendly аппликейшн нь иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Монгол улсаас Дэлхийн 170 гаруй оронд байгаа хүлээн авагчийн банкны карт руу түргэн шуурхай, найдвартай, хялбар аргаар шилжүүлэг хийх боломжийг хэрэглэгчдэдээ олгож байна.




- Аюулгүй
- Хэмнэлттэй
- Дурын банкны дансанд мөнгө хүлээн авах боломжтой
- Зах зээлд өрсөлдөхүйц ханш
- Хурдан, шуурхай
- Дансаа удирдах боломж

Мөнгөн гуйвуулгын мэдээ



Нийгэмд үзүүлсэн үр нөлөө, нийгмийн хариуцлага

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, НДШ (сая төгрөг)



Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарт олгосон хүү, ногдол ашиг (сая төгрөг)



Нийгэмд үзүүлсэн үр нөлөө, нийгмийн хариуцлага

“Аутист артистууд” хөгжмийн наадамд ивээн тэтгэгчээр оролцсон



Монголын Аутизмын Холбоо Аутизмтай авьяаслаг хүүхэд залуусын хөгжмийн наадмыг Монгол улсын Филармонитай хамтран 2023 оны 10 дугаар сард анх амжилттай зохион байгуулсан. Аутизмтай олон хүүхэд залуус хөгжмийг маш нарийн сонсож, мэдэрч, хүлээж авч тайзан дээр од болон гялалзан, өөрийн сурсан аялгуугаа үе тэнгийхэн болон найз нөхөд, гэр бүл, аав ээждээ тоглож өгсөн мартагдашгүй өдрийн нэг байсан.

Аутизмын хөдөлгөөн

“Сэндли” ББСБ ХК-ийн хамт олноос “Монголын Аутизмын холбоо”-той хамтын ажиллагааны хүрээнд 2023 оны 6 дугаар сард хийгдсэн олон улсын мөнгөн гуйвуулгын нийт гүйлгээний шимтгэлийн орлогоос 5%-ийг хүүхдийн төлөөх үйл ажиллагаанд зориулан хандивлалаа.



Улаанбаатар Марафон 2023

“Улаанбаатар марафон 2023” олон улсын гүйлтийг хоёр дахь жилдээ ивээн тэтгэгчээр оролцож, залуу үеийнхэнд өөрийн дотоод нөөц боломжийг нээж, зорилгодоо хүрэх тэсвэр хатуужил, бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэдийн өдөр тутам биеийн тамираар хичээллэх идэвхи санаачилгыг дэмжин ажилласан.



Нийгэмд үзүүлсэн үр нөлөө, нийгмийн хариуцлага



Тэрбум мод үндэсний хөдөлгөөн

"Дэлхийн Монголчуудын Төгөл" төслийн хоёр дах удаагийн мод тарилт 2023 оны 5 дугаар сард хийгдлээ. Тус төсөл нь дэлхийн өнцөг булан бүрд амьдарч буй монголчууд эх орондоо байгаа, уулзаж чадаагүй хайртай дотны хүмүүстээ хүндэтгэл үзүүлэх, дурсан санах, мөн үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилготой дурсгалын модыг хамтдаа тарьж нандин дурсамж, дурдатгал бүтээх, эко ногоон төгөл юм. Сэндли апп-аар дамжуулж захиалга хийж хандивласан модыг таны нэрээр нэрлэн QR коджуулж хайртай дотны хүмүүстээ өөрийн дуу хоолойгоор мэндчилгээ хүргэж, модны ургацын үйл явцаа харах боломжтой технолигт суурилсан эко төгөл байх юм. Минж үржүүлгийн төвд 2023 оны 9 дүгээр сард агч мод тарьсан.

Ид шидийн орон төсөл

"Сэндли ББСБ" ХК-ийн Хэнтий салбар нь Мегаболл ХХК-тай хамтран Ид шидийн орон төсөлд тоглоом, ном, үнэ бүхий зүйл, 2023 оны 8 дугаар сард 2-р цэцэрлэгийн тусгай бүлгийн хүүхдүүдэд тоглоом тус тус бэлэглэсэн.



Харилцагчийн үйлчилгээ

	Үзүүлэлт	Биелэлт
Чатботоор мэдээлэл авсан:	1,859	100%
Олон улсаас ирсэн дуудлага:	364	97%
Оператортой холбогдон мэдээлэл авсан:	611	97%
Дотоодоос залгасан дуудлага:	1,798	98%
И-мэйлд хариу өгсөн:	3,712	100%





02.

Санхүүгийн тайлагнал

Аудитын дүгнэлт

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

СЭНДЛИ ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид СЭНДЛИ ББСБ ХК (цаашид "компани" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "МНБЕЗ-н дүрэм" гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЕЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга

Аудитын дүгнэлт

материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурсан:



И.Гүржармаа
Гүйцэтгэх захирал
Хүлэгтхүннү Аудит ХХК

2024 оны 02 дугаар сарын 19-ны өдөр
Монгол Улс, Улаанбаатар хот

Санхүү байдлын тайлан

(сая төгрөг)	2021.12.31	2022.12.31	2023.12.31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,169	8,392	14,239
Зээлийн багц (Нийт)	8,608	23,139	42,332
Зээлийн эрсдэлийн сан	(8)	(664)	(1,650)
Бусад хөрөнгө	625	3,637	7,967
Үндсэн ба биет бус хөрөнгө	210	388	639
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,604	34,892	63,527
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,580	10,437	19,491
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	100	2,228	5,950
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	-	-	8,500
Бусад өр төлбөр	764	801	2,732
Нийт өр төлбөр	3,444	13,466	36,673
Өөрийн хөрөнгө	7,160	21,426	26,855
Энгийн хувьцаа	6,429	11,179	11,179
Нэмж төлөгдсөн капитал	-	6,285	6,285
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	143	883	3,320
Тухайн үеийн хуримтлагдсан ашиг	588	3,064	6,056
Бусад өөрийн хөрөнгө	-	15	15
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,604	34,892	63,528

Орлого үр дүнгийн тайлан

(сая төгрөг)	2021.12.31	2022.12.31	2023.12.31
Хүүгийн орлого	558	3,825	14,902
Хүүгийн зардал	1	531	1,952
Цэвэр хүүгийн орлого	557	3,294	12,950
Хүүгийн бус орлого	1,808	7,825	6,406
Хүүгийн бус зардал	1,707	6,964	11,617
Цэвэр хүүгийн бус орлого	101	861	(5,211)
Болзошгүй эрсдлийн зардал	8	657	986
Нийт үйл ажиллагааны орлого	650	3,498	6,753
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	10	299
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	30	104	171
Татварын өмнөх ашиг	620	3,404	6,881
Орлогын албан татвар	32	340	827
Тайлант үеийн цэвэр ашиг	588	3,064	6,054

Мөнгөн гүйлгээний тайлан

(сая төгрөг)	2021.12.31	2022.12.31	2023.12.31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	274	7,327	6,025
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	2,199	11,660	19,518
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	1,925	4,333	13,493
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(30)	(104)	(178)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	244	7,223	5,847
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	925	1,169	8,392
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	1,169	8,392	14,239

Өмчийн өөрчлөлтийн тайлан

(сая төгрөг)	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,178.5	6,284.8	14.72	835.0	18,313.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	48.5	48.5
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	3,064.3	3,064.3
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,178.5	6,284.8	14.72	3,947.8	21,425.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(627.91)	(627.91)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	0.4	-	0.4
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	6,055.4	-
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,178.5	6,284.8	15.11	9,375.3	26,853.7

Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд Зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, журам, эрх зүйн актанд нийцүүлэн 2023 онд “Эрсдэлийн удирдлагын бодлого”, “Авлигын эсрэг бодлого”, “Эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт тавих журам”, Мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой журам заавруудыг шинэчлэн баталж ажилласан. ББСБ-ын зээл, зах зээл, үйл ажиллагааны эрсдэлийг улирал бүр тодорхойлон ТУЗ-д танилцуулан ажиллаж байна.

Дотоод аудитын тогтолцоо

Дотоод аудит нь ББСБ-ын үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бий болгон салбарын хууль, журам, зааварт нийцэж байгаа эсэхэд хяналт тавиж, эрсдэлээс урьдчилан сэргийлж зөвлөмж гарган ажиллаж байна. 2023 онд салбар нэгжид газар дээрх болон зайны хяналт шалгалтыг гүйцэтгэж, сар бүр зайны хяналтын тайлан боловсруулан ажиллаж байна.

Байгаль орчин, нийгмийн бодлого, эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Сэндли ББСБ ХК нь “Тогтвортой санхүүжилт”-ын бодлого, холбогдох дүрэм журмыг боловсруулан ажиллаж байна. Бодлогодоо байгаль орчин, нийгэмд өндөр хор хөнөөлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхээс татгалзах, тус төрлийн санхүүжилтийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтыг олон улсын шаардлагын дагуу тухай бүр шинэчлэхээр тусган ажиллаж байна. Сэндли ББСБ ХК нь ТоС холбооны гишүүнээр нэгдээд 3 дахь жилдээ хамтран ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд Монгол улсын Тогтвортой санхүүгийн хөтөлбөр, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос дэвшүүлж буй зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс байгууллагынхаа



дотоод үйл ажиллагаанд “Тогтвортой санхүүжилт”-ын Бодлого холбогдох дүрэм журмыг боловсруулан ажиллаж байна. Шинээр батлагдсан “Тогтвортой хөгжлийн зорилтын санхүүжилтийн таксономи”-той уялдуулан бид шинээр олгож буй зээл бүрт эдийн засгийн ангилал болон дэд ангиллыг таксономийн дагуу бүртгэж зээл бүрийг ангилах боломжийг дотоод програмдаа бий болгосон.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Сэндли ББСБ ХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн хугацаанд бүрэн ханган ажиллаж байна.

Харьцаа үзүүлэлт	Байвал зохих	2021	2022	2023
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	46.6%	41.9%	40.2%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	46.6%	42.0%	40.2%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	46.2%	43.1%	43.8%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	16.6%	18.4%	8.8%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	/+/-40%/	-10.5%	-23.5%	-26.2%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	62.0%	78.7%	79.0%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	38.1%	36.1%	33.8%

2024 онд үйл ажиллагаанд учирч болох топ эрсдэлүүд

Топ эрсдэлүүд	Юу тохиолдож болох вэ?	Эрсдэлийг удирдахын тулд бид юу хийж байна вэ?
Ам долларын ханшийн эрсдэл	2024 он сонгуулийн жил. Хэрэглээг дэмжсэн мөнгөний нийлүүлэлт нь төгрөгийн ханшийг ам.долларын эсрэг унах. Ханшийн тэгшитгэлээс хүлээх алдагдал нэмэгдэх эрсдэлтэй.	ББСБ-ын хувьд мөнгөн гуйвуулгын үйлчилгээний хүрээнд ам долларыг арилжааны банкны дансанд байршуулж, долларын ханшийн эрсдэлийг бууруулан ажиллана. Итгэлцэл ам доллараар авахгүй байх.
Зээлийн эрсдэл NPL	Хугацаа хэтэрсэн, ангилагдсан зээл өсөх, NPL алдагдах эрсдэл нэмэгдэх.	Зээлийн өргөдлийн маягтыг шинэчлэх, өр орлогын харьцааг чангаруулах, зээлийн судалгааны чанарыг сайжруулах, хорооны шийдвэрт нөлөөлөх хувь хүний хандлагыг бууруулж автомат болгох, хариуцлагын тогтолцоог чангатгах.
Зээлийн эрсдэл (Хэрэглэгчдийн бодит орлого буурах, хэрэглээний шилжилт, Байгаль орчны эрсдэл)	Эдийн засаг хямарснаар иргэдийн бодит орлого буурах, худалдан авах чадвар сулрах. Зээлдэгчийн зээл төлөх чадвар муудах, хугацаа хэтэрсэн зээл өсөх сөрөг нөлөө бий болох. Байгалын онц аюултай үзэгдэл, цасан шуурга, малын хорогдол. Малчны зээл муудах эрсдэл.	Зээлийн скорингийн үнэлгээг бүрэн нэвтрүүлнэ. 5 жилийн түүхэн мэдээлэлд үндэслэн уг үнэлгээнд зээлдэгчийн бизнесийн төрөл, салбар, мэргэжил, нас, хүйс, зээлийн түүх, орлого, байршил зэрэг 20 гаруй индикатор үзүүлэлтийг харгалзан тооцно. Малчны зээлийн шинэ олголтын дээд хэмжээг бууруулах, малчны зээлийн өргөдлийг маягтыг чангаруулах.
Үйл ажиллагааны эрсдэл (Кибер аюулгүй байдал)	ББСБ-ын үндсэн програм хангамж, системд доголдох, алдаа гарах, халдлага бий болох, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, зээлдэгч нар АПП нууц үг алдах эрсдэл нэмэгдэх.	Мэдээллийн технологи хариуцсан нэгжийн зүгээс “МТ системийн үйл ажиллагааны тасралтгүй байдлын төлөвлөгөө”, “Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн үед ажиллах журам”, “МТ систем сүлжээнд хандах хандалтыг хянах журам” мөрдөн ажиллах, хэрэгжүүлэх. Салбаруудаар дамжуулан харилцагч нарт мэдээлэл өгөх.

Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн хурал

“Сэндли ББСБ” ХК нь 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр Bluesky зочид буудлын 2 давхар Emerald танхимд болон khural.mn вэб ашиглан зохион байгуулсан ба саналын эрх бүхий хувьцааны 70.06 хувь оролцож хурал хүчин төгөлдөр болсон. Тус хурлаар дараах үндсэн 2 асуудлыг хэлэлцэн баталсан.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг хэлэлцэн батлах,
2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв батлах.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮД:



Б.НАРАНБАТ
ТУЗ - ийн дарга
Санхүүч

Сангийн Яам
Төрийн Банк
Монголиан Финтек Групп ХК



М.ЦОЛМОН
ТУЗ - ийн гишүүн
Санхүүч

Сангийн Яам
Тариалан Зохиолтийг
Дэмжих Сан
Mongol Alt ХКХ



Б.ЭРДЭНЭ
ТУЗ - ийн гишүүн
Санхүүч

Сангийн Яам
Төрийн Банк
Төлбөрс ХХК



Н.ЦЭВЭГМИД
ТУЗ - ийн гишүүн
Санхүүч

Райнос Инвестмент ҮЦК ХХК,
Мира Эссет Сельеритис ҮЦК ХХК



Л.НАРАНТУЯА
ТУЗ - ийн гишүүн
хуульч

Зоос Банк,
Төрийн Банк
Монголиан Финтек Групп ХК



Н.БИЛГҮҮН
ТУЗ - ийн гишүүн
Санхүүч

Сангийн Яам
Sellsia Nomads ХХК
Investlab BN CM ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Б.АНУЖИН
ТУЗ - ийн хараат
бус гишүүн

Азийн Сан
Экст Экс Р-с Монголиа Аудит ХХК
Central TV



Ц.САРУУЛТУЯА
ТУЗ - ийн хараат
бус гишүүн

Тогролт Банк
Талаань ШУТИС
МИИС Бизнесийн сургууль



Б.ЦЭЛМЭГ
ТУЗ - ийн хараат
бус гишүүн

JP Morgan
SMBC Aviation Capital
Увс Банк
Ашид Капитал ХХК

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Төлөөлөн удирдах зөвлөл:

- ТУЗ-ийн дарга Б.Наранбат
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Мөнхцэцэг

Эрсдэлийн удирдлагын хороо:

- Дарга Б.Цэлмэг
- Гишүүн Б.Эрдэнэ
- Гишүүн Ц.Саруултуяа

Аудитын хороо:

- Дарга Б.Анужин
- Гишүүн Б.Цэлмэг
- Гишүүн Н.Билгүүн

Цалин урамшуулал нэр дэвшүүлэх хороо:

- Дарга Ц.Саруултуяа
- Гишүүн Б.Анужин
- Гишүүн Л.Нарантуяа

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулсан чиг үүрэг бүхий Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо 2023 онд чиг үүргийн хүрээнд тус бүр 2 удаа хуралдаж аудитын компани сонгох, компанийн үйл ажиллагаанд шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж гарган ажилласан.


Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, үйл ажиллагаа

“Сэндли ББСБ” ХК-ийн ТУЗ-ын ээлжит хурал 2023 онд 5 удаа хуралдан компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэн тухай бүр шийдвэрлэн ажилласан байна.

Хэлэлцсэн онцлох асуудал:

- 8.5 тэрбум төгрөгийн нээлттэй бондын нийт үнийн дүн, бондыг эргүүлэн худалдан авах үнэ, нөхцөл баталсан.
- 2022 оны татварын дараах цэвэр ашгаас компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 2.75 төгрөгөөр тогтоож, 2022 оны цэвэр ашгаас 20.064 хувь буюу 614,817,500 төгрөгийг мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн.
- Компанийн засаглалын кодексын шаардлагын дагуу хараат бус үйл ажиллагаа явуулах комплайнсын мэргэжилтэнг ТУЗ-ийн хурлаас томилсон.
- Компани нь сонирхлын зөрчилтэй 6 хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай асуудлуудыг шийдвэрлэсэн.
- 2023 онд нийт 2 бодлого журам шинээр баталсан.

Хувьцааны ханш



Үнэт цаасны код:	7914
Зах зээлийн үнэлгээ:	37,456,917,800
Хаалтын ханш: (2023.12.29)	167.54
Гаргасан хувьцааны тоо ширхэг:	223,570.00
Хувьцаа эзэмшигчдийн тоо: (2023.12.31)	5,646

IPO-с хойш:

11.7% ▲

P/E

6.22

P/B

1.12

Ногдол ашгийн бодлогын хэрэгжилт

“Сэндли” ББСБ ХК 2022 оны санхүүгийн тайландаа “Шонхор үнэлгээ аудит” ХХК-иар аудит хийлгэж, компанийн цэвэр ашгийн 20.064 хувь буюу 614,817,500 төгрөгийг хувьцаа эзэмшигч нартаа хуваарилахаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд нэгж хувьцаанд ногдох ашиг нь 2.75 төгрөг байхаар тогтсон байна.

“Сэндли ББСБ” ХК нь 2022 оны есдүгээр сард компанийнхаа 29.97 хувийг олон нийтэд санал болгосноор нээлттэй хувьцаат компани болсон ба IPO хийснээс хойш хувьцаа нь идэвхитэй арилжаалагдаж, 2023 оны нэгдүгээр сарын 20-нд Монголын хөрөнгийн биржийн “ТОП 20” индекст багтсан. 2022 оны ногдол ашгаа “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд мөнгөн хэлбэрээр байршуулж, 2023 оны долдугаар сард хувьцаа эзэмшигч нарын дансанд бүрэн төвлөрүүлэн ажилласан.

Бизнес төлөвлөгөөний дагуу 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар “Сэндли ББСБ” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5.6 төгрөг буюу нийт 1,251,991,232.27 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.



Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,
40,50 мянгат Бакула ренбүчи гудамж 8/4
Утас: +976 77997700
Вэбсайт: www.sendly.mn